



Өмнөговь аймаг дахь төрийн аудит газар

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН 2023 ОНЫ
ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ
АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

2022 он



АЙМГИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГСӨН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

ТӨСВИЙН ОРЛОГО
НЭМЭГДҮҮЛЭХ САНАЛ

ТӨСВИЙН ЗАРЛАГА
БУУРУУЛАХ САНАЛ

ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТИЙН
ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ



Монгол
Улсын Их


Улсын Их Хурлаас Өмнөговь аймгийн 2023 оны суурь орлогыг 367,980.6 сая төгрөгөөр, суурь зарлагыг 391,256.8 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн Засаг даргын өргөн барьснаар 2023 оны төсвийн төсөлд орлого, зарлагын дүнг 615,069.6 сая төгрөгөөр тооцсон байна.



Аймгийн
Засаг дарга

Аймгийн 2023 оны төсвийн төслийг 2022 оны баталсан төсөвтэй харьцуулбал:




Аймгийн 2023 оны төсвийн төслийн орлогын задаргаа:



Төсвийн төсөлд татварын орлогыг 30,494.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэхдээ тооцоо судалгаан дээр үндэслээгүй байна. Энэ нь орлогын төлөвлөгөө тасрах эрсдлийг үүсгэж байна.

Аймгийн 2023 оны төсвийн төслийн зарлагын задаргаа:



Аймгийн 2023 оны төсвийн төсөлд суурь зарлагыг Сангийн яамны баталсан дээд хязгаараас 223,812.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн байна. Өмнөговь аймаг нь улсын төсөвт орлого төвлөрүүлдэг санхүүгийн хувьд бие даасан байдал нь зарлагын дээд хязгаарыг нэмэгдүүлэн төлөвлөхөд нөлөөлсөн байна.

АЙМГИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙН ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ САНАЛ



Төрийн аудит

Аймгийн 2023 оны төсвийн төслийн орлогыг 1,840.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна. Үүнд

- Татварын орлогыг 1,245.4 сая төгрөг,
- Татварын бус орлогыг 595.2 сая төгрөг,

Аймгийн 2023 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх санал:

01

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн өв загамжлал, бэлэглэл чиглэлээр хийсэн гэрээнд хамгийн бага үнээр төлбөр тогтоож, 5 хувийн татвар ногдуулахад төсвийн орлого 45.3 сая төгрөгөөр нэмэгдэх боломжтой

02

Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тооцох аргачлал”-ын дагуу шинэчлэн тогтоосноор төсвийн орлого 1,200.1 сая төгрөгөөр нэмэгдэх боломжтой

03

Аймгийн Засаг даргын Тамгын газраас зээлийн гэрээ байгуулан 6 иргэнд олгосон 229.9 сая төгрөгийн зээлийн үлдэгдэл 155.3 сая төгрөгийг барагдуулснаар төсвийн орлого 155.3 сая төгрөгөөр нэмэгдэх боломжтой

04

Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг гэрээний дагуу орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлээгүй зөрчилд Төрийн аудитын байгууллагаас тогтоосон 501.2 сая төгрөгийн төлбөрийн актын үлдэгдэл 6 сумын 341.1 сая төгрөгийг барагдуулснаар төсвийн орлого нэмэгдэх

05

Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын хөрөнгийн түрээсийг гэрээ байгуулсан сараар тооцсон байна. Хөрөнгийн түрээсийг бүтэн жилийн хугацаанд түрээслэхээр тооцоход төсвийн орлого 23.4 сая төгрөгөөр нэмэгдэх

06

Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагад ашиглаж байсан 22 автомашиныг дуудлага худалдаагаар худалдахдаа анхны үнийг үлдэх өртгөөс нь дээш үнээр тогтоосноор 75.4 сая төгрөгөөр төсвийн орлого нэмэгдэх боломжтой

АЙМГИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙН ЗАРЛАГЫГ БУУРУУЛАХ САНАЛ



Төрийн аудит

Аймгийн Засаг дарга боловсруулсан 615,069.6 сая төгрөгийн 2023 оны төсвийн төслийн зарлагыг 21,583.1 сая төгрөгөөр бууруулах боломжтой байна.

Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний ажлуудыг төрийн хэмнэлтийн горимыг баримтлан төсвийг оновчтой байхаар төлөвлөн, Төсвийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэх шаардлагатай байна.

Аймгийн 2023 оны төсвийн зарлага бууруулах санал:

01

Орон нутгийн 2023 оны төсвийн төсөлд хөрөнгө оруулалтын жагсаалтад зураг төсөвгүй 1,400.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг хассанаар төсвийн зарлага буурах боломжтой

02

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцээгүй төрийн болон үйлчилгээний байгууллагын хэрэгцээнд автомашин худалдан авахад зарцуулах 80.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг хассанаар төсвийн зарлага буурах боломжтой

03

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцээгүй орон нутгийн хөрөнгөд бүртгэх боломжгүй 7,542.8 сая төгрөгийн 8 төсөл арга хэмжээг хассанаар төсвийн зарлага буурах боломжтой

04

ОНХС-гийн журам зөрчсөн тооцоо судалгаагүй, ТЭЗҮ болон зураг төсвийг магадлалаар баталгаажуулаагүй 9,725.9 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээг хассанаар төсвийн зарлага буурах боломжтой

05

“Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын заалттай нийцээгүй 25.0 сая төгрөгийн 1 арга хэмжээг хассанаар төсвийн зарлага буурах боломжтой

06

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 291.2.4 дахь заалттай нийцэхгүй тооцоо, судалгаагүй орон нутгийн чанартай авто замын засвар арчлалт хийхэд 1,800.0 сая төгрөг зарцуулахаар төсөвлөснийг хассанаар төсвийн зарлага буурах боломжтой

07

Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж “Буянт хотхон” УТУГ-ын орон тооны дээд хязгаар, бүтцийн жишгийг батлахдаа дэд дарга, ордны дарга гэсэн орон тоог баталж цалингийн зардалд 51.2 сая төгрөг төлөвлөснийг хассанаар төсвийн зарлага буурах боломжтой

08

Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн засаг даргын тамгын газрын бүтэц орон тооны хязгаарыг тогтоох тухай” 2.2-т заасантай нийцээгүй аймгийн Засаг даргын Тамгын газарт 11 орон тоо нэмэгдүүлэн цалингийн зардалд тусгасан 223.3 сая төгрөгийг хассанаар төсвийн зарлага буурах боломжтой

09

Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолоор баталсан суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтны жагсаалтад тусгаснаас илүү 1 автомашины шатахууны зардал, жолоочийн цалингийн зардалд нийт 27.0 сая төгрөг төлөвлөснийг хассанаар төсвийн зарлага буурах боломжтой

10

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д заасантай нийцэхгүй аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 33 төлөөлөгчдийн урамшууллын зардалд 707.9 сая төгрөг төлөвлөснийг хассанаар төсвийн зарлага буурах боломжтой

АЙМГИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТ, ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ



Төрийн аудит

Аймгийн 2023 оны төсвийн төслийг боловсруулахдаа Өмнөговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд тусгасан зорилт арга хэмжээтэй уялдуулан төлөвлөсөн байна.

Аймгийн 2023 оны төсвийн санхүүжилт, үр ашгийг дээшлүүлэх:

01

Аймгийн 2023 оны төсвийн төслийн танилцуулгад төсвийн тэнцлийн зорилтот үзүүлэлтийг тооцсон байдал, санхүүжилтийг зогсоох болон багасгах хөтөлбөр, арга хэмжээний жагсаалт, түүний төсөвт үзүүлэх нөлөөлөл, тайлбар, төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тооцсон байдал, хөтөлбөр, арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, тэдгээртэй холбогдсон тайлбар, танилцуулга зэргийг тусгаагүй байна.

02

Төсвийн төсөл боловсруулахдаа төсвийн тооцоололгүй, багц дүнгээр тоймлон тооцсон байна. Хүрэх үр дүнг бодитой тодорхойлоогүй, төсвийн тооцоо хийгээгүй, 2,473.5 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээг хуульд нийцүүлэн дахин төлөвлөн үр ашиг дээшлэх боломжтой

03

Төсвийн төслийг боловсруулахдаа хөтөлбөрт тусгасан зорилт арга хэмжээний хүрэх үр дүнг чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтээр бодитой илэрхийлэх, хуулийн шаардлагад нийцсэн хөрөнгө оруулалтыг тусган, өмнөх аудитаар өгсөн саналыг бүрэн тусгаснаар төсвийн санхүүжилтийн үр ашиг дээшлэх боломжтой байна.

АЙМГИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР



Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс болон аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

01

Аймгийн бүх шатны төсвийн байгууллага төрийн хэмнэлтийн горимыг мөрдөж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх,

02

Орлого, зардлыг бодитой төлөвлөж, дээрх зөрчлийг арилган, төсвийн төлөвлөлтийн үр ашгийг сайжруулах,

03

Хүрэх үр дүнг бодитой тодорхойлоогүй, төсвийн тооцоо хийгээгүй 2,473.5 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээг хуульд нийцүүлэн дахин төлөвлөх шаардлагатай байна.

04

Өмнөх оны аудитаар ТЭЗҮ хийгдээгүй, зураг төсөвгүй 3,400.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээг батлахгүй байх санал хүргүүлсэн боловч 2023 оны төсвийн төсөлд мөн дээрх зөрчил давтагдаж байна.

05

Өмнөх аудитаар өгсөн саналыг бүрэн тусгаснаар төсвийн санхүүжилтийн үр ашиг дээшлэх боломжтой байна.